**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
# ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 06 өдөр Дугаар 92 Номгон

Нийтийн сонсгол зохион байгуулах тов
зарлах, даргалагч томилох тухай

Монгол Улсын Нийтийн сонсголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн сонсгол зохион байгуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 6 дахь зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Баянхонгор сумын 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын үр дүн" сэдэвт нийтийн сонсголыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт зохион байгуулсугай.

2. Нийтийн сонсгол даргалагчаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Т.Эрдэнэбатыг томилсугай.

3. Нийтийн сонсголын товыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаж, холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг сонсгол даргалагч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОТГОНБАЯР

1190 87

D:/2018/Alban bichig/th togtool-2019